

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “JK-730 өрмийн машин /2 нэгж/, компрессор 300SCY /3 нэгж/, SEM656D дугуйт ачигчийн сервис үйлчилгээ болон түүнд шаардлагатай сэлбэг нийлүүлэх” (3 багц)

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012316

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос “JK-730 өрмийн машин /2 нэгж/, компрессор 300SCY /3 нэгж/, SEM656D дугуйт ачигчийн сервис үйлчилгээ болон түүнд шаардлагатай сэлбэг нийлүүлэх” тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2019 онд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-аас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-аас багагүй байна.**

Тендерийн хамт:

Багц 1 – 577200 /таван зуун далан долоон мянга хоёр зуу/

Багц 2 - 577200 /таван зуун далан долоон мянга хоёр зуу/
төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 14:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 14:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 305 тоот өрөө, утас: 450060 + 243

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ